



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/57

Есөнбулаг

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх улсын чанартай авто замыг Шарга сумтай холбох, 23.0 км (Говь-Алтай, Шарга сум)-ийн ажлын зураг төсөл боловсруулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга)

Гишүүд: Д.Гаадамба (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)


С.Дугарсүрэн (Хөндлөнгийн төлөөлөл)  
(тохиролцсон)

Ж.Бодьгэрэл (Есөнбулаг сумын иргэн)

Нарийн бичиг: Б.Эрхбаяр (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай, шуурхай зохион байгуулж, үр дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг үнэлгээний хороо (Д.Алтанзагас)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

